



1925

УЛСЫН НЭГДҮГЭЭР ТӨВ ЭМНЭЛГИЙН ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2023 оны 06 сарын 16 өдөр

Дугаар А/165

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Эрүүл мэндийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.1 дэх заалт, 42 дугаар зүйлийн 42.1 дэх хэсэг, Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор батлагдсан “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”-ын 1.3 дахь хэсэг, Чанарын менежментийн тогтолцоо ISO 9001:2015 Монгол Улсын стандарт, Байгууллагын хөдөлмөрийн дотоод хэм хэмжээний 3 дугаар зүйлийн 3.2.7 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Улсын нэгдүгээр төв эмнэлгийн дотоод хяналт, шалгалтын журам”-ыг хавсралтаар баталсугай.

2. Журмыг эмнэлгийн нэгж, ажилтнуудад мэдээлэх, мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх ажлыг зохион байгуулж, хэрэглээнд хяналт тавьж ажиллахыг Захирлын ажлын алба (Ц.Амаржаргал)-нд даалгасугай.

3. Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Сургалт, эрдэм шинжилгээ, инноваци эрхэлсэн дэд захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (П.Анхтуяа)-д үүрэг болгосугай.

ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Б.ХИШИГЖАРГАЛ

001088

 УЛСЫН НЭГДҮГЭЭР ТӨС ОМХОЛДОР	ДОТООД ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫН ЖУРАМ		
	Хүчин төгөлдөр хэрэгжих хугацаа 2023/.... /....	Хувилбар 1	Журмын дугаар УНТЭ -ЗАА -ДХШЖ

Улсын нэгдүгээр төв эмнэлгийн ерөнхий
захирлын 2023 оны 06 дугаар сарын 16 -ны
өдрийн А/165 дугаар тушаалын хавсралт



ДОТООД ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫН ЖУРАМ

 УЛСЫН НЭГДҮГТЭЭР ТӨС ХАМГААХ	ДОТООД ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫН ЖУРАМ		
	Хүчин төгөлдөр хэрэгжих хугацаа 2023/.... /....	Хувилбар 1	Журмын дугаар УНТЭ –ЗАА-ДХШЖ

БАТАЛГААЖУУЛАЛТ

Энэхүү журмыг боловсруулсан, хянасан, баталсан болоод хүчин төгөлдөр байдлыг дараах хүснэгтээр баталгаажуулна.

	АЛБАН ТУШААЛ	НЭР	ГАРЫН ҮСЭГ	ОГНОО
БОЛОВСРУУЛ САН	Захирлын ажлын албаны дотоод хяналтын мэргэжилтэн	Б.Энхтуул		2023.01
ХЯНАСАН	Захирлын ажлын албаны дарга, ISO9001:2015 Чанарын менежментийн тогтолцоог нэвтрүүлэх ажлын хэсгийн нарийн бичгийн дарга	Ц.Амаржаргал		2023.01
	Сургалт, эрдэм шинжилгээ, инноваци эрхэлсэн дэд захирал, ISO9001:2015 Чанарын менежментийн тогтолцоог нэвтрүүлэх ажлын хэсгийн дарга	П.Анхтуяа		2023.02

 УЛСЫН НЭГДҮГЭЭР ᠤᠯᠤᠰ ᠤ ᠨᠡᠭᠳᠦᠭᠦᠷ	ДОТООД ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫН ЖУРАМ		
	Хүчин төгөлдөр хэрэгжих хугацаа 2023/.... /....	Хувилбар 1	Журмын дугаар УНТЭ –ЗАА-ДХШЖ

АГУУЛГА

Д/д	Гарчиг	Хуудас
1.	Нийтлэг үндэслэл	5
2.	Нэр томьёо ба тодорхойлолт	5
3.	Урсгал диаграмм	6
4.	Үндсэн үйл ажиллагаа	7-8
5.	Гүйцэтгэлийн шалгуур (хэмжүүр)	8
6.	Эрх үүрэг	8-10
7.	Хариуцлага	10
8.	Холбогдох баримт бичиг	10
9.	Бусад	10
10.	Хавсралт	11-15

 УЛСЫН НЭГДҮГЭЭР ШАЛГАЛТЫН АЖИЛЛАГАА	ДОТООД ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫН ЖУРАМ		
	Хүчин төгөлдөр хэрэгжих хугацаа 2023/.... /....	Хувилбар 1	Журмын дугаар УНТЭ -ЗАА -ДХШЖ

1. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1 Энэхүү журмын зорилго нь Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор батлагдсан “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт, шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”-ыг үндэслэн байгууллагын хэмжээнд зохион байгуулагдах дотоод хяналт, шалгалтын үйл ажиллагааг зохицуулахад оршино.
- 1.2 Дотоод хяналт, шалгалтын үйл ажиллагаа нь эмнэлгийн өдөр тутмын үйл ажиллагаандах хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, зөвлөмж гаргах, удирдлагыг шаардлагатай үнэн, бодит мэдээллээр хангах, эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлж, тухайн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахад дэмжлэг үзүүлэн ажиллана.
- 1.3 Энэхүү журмаар зохицуулах дотоод хяналт, шалгалтын хамрах хүрээнд санхүүгийн хяналт шалгалт хамаарагдахгүй болно.
- 1.4 Байгууллагын санхүүгийн дотоод аудит болон бодлогын бичиг баримтын хяналт-шинжилгээ, үнэлгээг тусдаа журмаар зохицуулна.

2. НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ


- 2.1 **Дотоод хяналт, шалгалт:** Тухайн байгууллага хууль тогтоомж, дүрэм журмыг даган мөрдөж, тэдгээрт нийцэж буй байдал, үйл ажиллагааны төлөвлөгөө болон үр ашигт байдлаа дээшлүүлэх, менежментийн бодлогын хэрэгжилт зэргийг хангуулахад чиглэсэн нягтлан шалгах үйл ажиллагаа;

 УЛСЫН НЭГДҮГЭЭР ТӨС АНГАЖЛАГ	ДОТООД ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫН ЖУРАМ		
	Хүчин төгөлдөр хэрэгжих хугацаа 2023/.... /....	Хувилбар 1	Журмын дугаар УНТЭ –ЗАА -ДХШЖ

3. УРСГАЛ ДИАГРАММ

3.1 Үндсэн үйл явцын зураглал

Дотоод хяналт, шалгалт хийх бүдүүвч зураг



 УЛСЫН НЭГДҮГЭЭР ТӨВ ЗАСГИЙН ГАЗРЫН ШИЙДВЭР	ДОТООД ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫН ЖУРАМ		
	Хүчин төгөлдөр хэрэгжих хугацаа 2023/.... /....	Хувилбар 1	Журмын дугаар УНТЭ –ЗАА -ДХШЖ

4. ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА

4.1 Дотоод хяналт, шалгалтад баримтлах үндсэн зарчим.

- 4.1.1 Хүний амь нас, эрүүл мэнд, нийгмийн болон орчны аюулгүй байдал нь бусад аливаа сонирхол, зорилгоос илүүд байх;
- 4.1.2 Хяналт, шалгалтыг хуульд заасан үндэслэлийн дагуу явуулах бөгөөд хяналт, шалгалт нь хараат бус, шударга, ил тод байх;
- 4.1.3 Хяналт, шалгалттай холбоотой зардлыг байгууллагын төсвөөс санхүүжүүлэх;
- 4.1.4 Шалгуулагч нэгж болон ажилтанд адил тэгш хандаж, түүний хууль ёсны эрх, ашиг сонирхол, нэр төрийг хүндэтгэн харилцах;
- 4.1.5 Хяналт шалгалтыг зөвхөн хууль болон нийтээр дагаж мөрдөхөөр бүртгэгдсэн эрх зүйн актыг үндэслэн явуулах;
- 4.1.6 Дотоод хяналт, шалгалтыг нэр, хаяггүй, тодорхой бус гомдлын мөрөөр явуулахыг хориглоно;
- 4.1.7 Дотоод хяналт, шалгалтыг төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бусаар хийнэ;

4.2 Төлөвлөгөөт дотоод хяналт шалгалт.

- 4.2.1 Хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын шийдвэр, нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон эрх зүйн актын хэрэгжилт болон тухайн аж ахуйн нэгж, байгууллагын хуулиар хүлээсэн үүргийн хэрэгжилтэд тавих хяналт, шалгалт;
 - 4.2.1.1 Байгууллагын болон салбарын хэмжээнд хэрэгжиж буй эрүүл мэндийн холбогдолтой төрийн захиргааны төв байгууллагаас баталж нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон эрх зүйн акт болон байгууллагын хуулиар хүлээсэн үүргийн хэрэгжилтэд тавих хяналт, шалгалт;
 - 4.2.1.2 Нийгмийн эрүүл мэндийн талаарх холбогдох эрх зүйн актын хэрэгжилтийн байдал, үр дүнд тавих хяналт, шалгалт;
 - 4.2.1.3 Байгууллагын хэмжээнд ажиллаж буй албан бус зөвлөлүүд, хороо, комиссын үйл ажиллагаанд тавих хяналт, шалгалт;
 - 4.2.1.4 Байгууллагын стратеги төлөвлөгөөний хэрэгжилтэд тавих хяналт, шалгалт;
 - 4.2.1.5 Байгууллагын тухайн жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт, биелэлт, үр дүнд тавих хяналт, шалгалт;
 - 4.2.1.6 Байгууллагын ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлтийн биелэлт, үр дүнд тавих хяналт, шалгалт;
 - 4.2.1.7 Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах чиглэлээр хийсэн үйл ажиллагаанд тавих хяналт, шалгалт;
 - 4.2.1.8 Болзошгүй гамшиг, ослоос урьдчилан сэргийлэх, онцгой байдлын үеийн бэлэн байдал хангах, хариу арга хэмжээний болон нөхөн сэргээх үеийн төлөвлөгөөний хэрэгжилтийн байдалд тавих хяналт, шалгалт;
- 4.2.2 Байгууллагын үйл ажиллагааны байгаль орчинд үзүүлэх нөлөөлөлд хийх хяналт, шалгалт;
 - 4.2.2.1 Цөмийн онош зүйн болон цацрагийн үүсгүүртэй рентген тоног төхөөрөмжийн байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг мэргэжлийн байгууллагаар үнэлүүлсэн байдалд хяналт хийх;
 - 4.2.2.2 Байгууллагын хог хаягдлын ангилан ялгалт, менежментэд хяналт хийх;
- 4.2.3 Эмнэлгийн хөдөлмөрийн нөхцөл, аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн шаардлага, хөдөлмөрийн дотоод журмын биелэлтэд тавих хяналт, шалгалт;
 - 4.2.3.1 Эмнэлгийн эрсдэлийн удирдлагын чиглэлээр хэрэгжүүлж буй үйл ажиллагааны хэрэгжилтэд;
 - 4.2.3.2 Хөдөлмөрийн нөхцөл аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн шаардлага, хөдөлмөрийн дотоод журмын биелэлтэд;
 - 4.2.3.3 Эмнэлгийн үйлдвэрчний эвлэлийн хороотой хамтран ажилласан байдал, хамтын гэрээний хэрэгжилтийн үр дүнд;

 УЛСЫН НЭГДҮГЭЭР ТӨЛӨВЛӨГӨӨТ	ДОТООД ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫН ЖУРАМ		
	Хүчин төгөлдөр хэрэгжих хугацаа 2023/.... /....	Хувилбар 1	Журмын дугаар УНТЭ –ЗАА -ДХШЖ

- 4.2.3.4 Эрүүл мэндийн ажилтны эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр хийсэн үйл ажиллагаанд;
 - 4.2.3.5 Эмнэлгийн тусламж үйлчилгээний явцад халдварт өртөх эрсдлийг бууруулах үйл ажиллагаанд;
 - 4.2.4 Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарт тавих хяналт шалгалт;
 - 4.2.4.1 Тусламж үйлчилгээний чиглэлээр мөрдөгдөж буй эрх зүйн актын хэрэгжилтийн байдалд;
 - 4.2.4.2 Эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд илэрсэн тохиолдлыг илрүүлсэн, бүртгэсэн, мэдээлсэн, залруулсан байдалд;
 - 4.2.5 Бусад чиглэлээр;
 - 4.2.5.1 Эрх бүхий байгууллагуудаас хийгдсэн хяналт, шалгалт, үнэлгээний дүн, зөвлөмжийн хэрэгжилтэд болон хэрэгжилтийг хангуулах байдалд;
 - 4.2.5.2 Гадны нийлүүлэгч болон түүний гаргаж байгаа үр дүнд хяналт тавих, гаднаас нийлүүлж буй үйл явц, бүтээгдэхүүн, үйлчилгээ шаардлага хангаж байгааг тогтооход;
 - 4.2.5.3 Чанарын менежментийн тогтолцооны аудитаар илэрсэн үл тохирлуудыг залруулах арга хэмжээний үйл явцад;
 - 4.2.5.4 Байгууллагын хэмжээнд хэрэгжиж буй гадаад, дотоод төсөл хөтөлбөрийн хэрэгжилтэд;
 - 4.2.6 Хяналт, шалгалтын төлөвлөгөөг дотоод хяналтын мэргэжилтэн /нэгж/ боловсруулан ерөнхий захирлаар батлуулан, гүйцэтгэлийг ханган ажиллана. Төлөвлөгөөт дотоод хяналт, шалгалтын үр дүнг улирал, хагас, бүтэн жилээр удирдлагын зөвлөлд танилцуулна.
- 4.3 Төлөвлөгөөт бус дотоод хяналт, шалгалт.
- 4.3.1 Төлөвлөгөөт бус хяналт, шалгалтыг эрх бүхий байгууллага болон дээд удирдлагын шийдвэр, хууль тогтоомжид заасан бусад үндэслэлээр хийнэ.
 - 4.3.2 Төлөвлөгөөт бус хяналт, шалгалтыг ерөнхий захирлын баталсан удирдамжийн дагуу зохион байгуулна.
 - 4.3.3 Удирдамжид заасан агуулгын хүрээнд дотоод хяналт, шалгалтын тайланг бичиж, ерөнхий захиралд тайлагнана.
 - 4.3.4 Дотоод хяналт, шалгалтаар илэрсэн хууль бус үйлдлийн мэдээллийг холбогдох эрх бүхий байгууллагад мэдээлнэ.

5. ГҮЙЦЭТГЭЛИЙН ШАЛГУУР (ХЭМЖҮҮР)

5.1 Дотоод хяналт, шалгалтын тайлан, дүгнэлтээр гүйцэтгэлийг хэмжинэ.

6. ЭРХ ҮҮРЭГ

6.1 Дотоод хяналт, шалгалтын чиглэлээр байгууллагын удирдлага дараах эрхтэй.

- 6.1.1 Дотоод хяналт, шалгалт хийх шийдвэр гаргах;
- 6.1.2 Төлөвлөгөөт бус хяналт, шалгалт хийх багийн бүрэлдэхүүнийг томилох;
- 6.1.3 Дотоод хяналт, шалгалт хийх удирдамж батлах;
- 6.1.4 Нууц баримт бичигтэй танилцах эрхийг олгох;
- 6.1.5 Дотоод хяналт, шалгалтын дүн, зөвлөмжид тулгуурлан ажил сайжруулах арга хэмжээ авах;
- 6.1.6 Дотоод хяналт, шалгалтын дүн, зөвлөмжид тулгуурлан, өгсөн зөвлөмжийг хангалтгүй биелүүлсэн албан тушаалтанд хариуцлага тооцох;
- 6.1.7 Хууль тогтоомжоор олгогдсон бусад эрх;

6.2 Дотоод хяналт, шалгалтын чиглэлээр байгууллагын удирдлага дараах үүрэгтэй.

- 6.2.1 Хууль тогтоомж, төрийн албаны ёс зүйн дүрмийг баримтлан ажиллах;
- 6.2.2 Дотоод хяналт, шалгалтыг байгууллагын бүх түвшинд зохион байгуулах боломжоор хангах;

 УЛСЫН НЭГДҮГЭЭР ТӨР ШИНЖЛЭГ	ДОТООД ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫН ЖУРАМ		
	Хүчин төгөлдөр хэрэгжих хугацаа 2023/.... /....	Хувилбар 1	Журмын дугаар УНТЭ –ЗАА -ДХШЖ

- 6.2.3 Дотоод хяналт, шалгалтын дүн, зөвлөмжид нөлөөлөхгүй байх;
- 6.2.4 Дотоод хяналт, шалгалтын үр дүн, зөвлөмжид дүн шинжилгээ хийж шаардлагатай арга хэмжээг авах;
- 6.2.5 Дотоод хяналт, шалгалт хийх шаардлагатай нөөцөөр хангах, шаардлагатай мэдээлэл, баримт, материалыг холбогдох нэгж, албан тушаалтнаас гаргуулан авах;

6.3 Байгууллагын дотоод хяналтын мэргэжилтэн /нэгж/ нь дараах эрхтэй.

- 6.3.1 Эрх бүхий албан тушаалтны баталсан төлөвлөгөө болон удирдамжийн дагуу дотоод хяналт, шалгалт хийх;
- 6.3.2 Эрүүл мэндийн салбарын хэмжээнд болон байгууллагын хэмжээнд мөрдөгдөж буй хууль, тогтоомж, эрх зүйн актыг сурталчилах, хэрэгжилтэд нь хяналт тавих удирдлагыг хэрэгжүүлэн ажиллах;
- 6.3.3 Байгууллага зорьсон зорилтдоо хүрэх боломжийг нэмэгдүүлэх, төрөөс баримтлах бодлогын үр дүн, гүйцэтгэлийг сайжруулах, дараагийн шатны үйл ажиллагааг төлөвлөхөд шаардлагатай мэдээллээр хангах, тайлагнах, хариуцлага тооцох тогтолцоог боловсронгуй болгох;
- 6.3.4 Хөндлөнгийн байгууллагуудаас хийгдэх хяналт, үнэлгээг хамтран зохион байгуулах;
- 6.3.5 Хяналт, үнэлгээний явцад холбогдох алба, төв, тасаг, нэгж, мэргэжилтнүүдийг татан оролцуулах, шаардагдах баримт бичиг, мэдээллийг гаргуулан авах, холбогдох ажилтны ажлыг шалгаж танилцах, илэрсэн зөрчил, дутагдлын талаар тайлбар гаргуулах;
- 6.3.6 Хяналт, шалгалтын ажлын дүн, авсан арга хэмжээг удирдлагад мэдээлэх;
- 6.3.7 Хяналт, шалгалтын мөрөөр авах арга хэмжээг хангалтгүй биелүүлсэн албан тушаалтан, эмнэлгийн ажилтан, албан хаагчдад хариуцлага тооцох саналыг хүргүүлэх;
- 6.3.8 Хууль тогтоомжоор олгогдсон бусад эрх;

6.4 Байгууллагын дотоод хяналтын мэргэжилтэн /нэгж/ нь дараах үүрэгтэй.

- 6.4.1 Дотоод хяналт, шалгалтын явцад олж авсан мэдээллийн нууцыг хадгалах
- 6.4.2 Дотоод хяналт, шалгалтын явцад олж авсан баримт бичгийг зөвхөн хяналт шалгалтын үйл ажиллагаанд ашиглах;
- 6.4.3 Аливаа асуудалд шударга, бодит байдалд нийцүүлэн хандах бөгөөд хувийн ашиг сонирхлоос ангид ажиллах;
- 6.4.4 Хяналт, үнэлгээний дүгнэлт, зөвлөмжийг хууль, тогтоомж болон баримт нотолгоонд тулгуурлан гаргах;
- 6.4.5 Байгууллагын үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэл, холбогдох хууль тогтоомж, дүрэм журам, стандартын хэрэгжилт болон зөрчлийн талаарх мэдээллээр удирдлагыг хангах;
- 6.4.6 Дотоод хяналт, шалгалтын явцад илэрсэн зөрчил дутагдлын шалтгаан нөхцөл байдлыг арилгах асуудлын талаар болон буруутай этгээдэд холбогдох хууль тогтоомж, тухайн байгууллагын дотоод журамд заасан хариуцлагыг ноогдуулах санал оруулах;
- 6.4.7 Дотоод хяналт, шалгалтын явцад илэрсэн зөрчил, дутагдал нь гэмт хэргийн шинжтэй бол асуудлыг хуулийн байгууллагад тавьж шийдвэрлүүлэх;
- 6.4.8 Хяналт, шалгалтын үр дүн, зөвлөмжийг удирдлагад тайлагнах;

6.5 Шалгуулагчийн эрх.

- 6.5.1 Хяналт, шалгалтын явцад шаардлагатай асуудлыг магадлах, тодорхой мэргэжил, мэргэшлийн дэмжлэг авах;
- 6.5.2 Төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт, шалгалтад биечлэн оролцох;
- 6.5.3 Шалгуулагч нэгж болон ажилтан нь хууль ёсны эрх, нэр төрөө хүндэтгүүлэн харилцах;

 УЛСЫН НЭГДҮГЭЭР ТӨР ШИНЖЛЭГ	ДОТООД ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫН ЖУРАМ		
	Хүчин төгөлдөр хэрэгжих хугацаа 2023/.... /....	Хувилбар 1	Журмын дугаар УНТЭ –ЗАА –ДХШЖ

6.5.4 Хяналт, шалгалтын үйл ажиллагаатай холбогдсон санал, гомдлыг холбогдох удирдах ажилтанд гаргах;

6.6 Шалгуулагчийн үүрэг.

- 6.6.1 Дотоод хяналт, шалгалтын мэргэжилтэн /нэгж/-ийг ажил үүргээ гүйцэтгэх нөхцөл, бололцоогоор хангах;
- 6.6.2 Дотоод хяналт, шалгалтын мэргэжилтэн /нэгж/-ийн шаардсан мэдээлэл, бичиг баримтыг дурьдсан хугацаанд гаргаж өгөх;
- 6.6.3 Дотоод хяналт, шалгалтын мэргэжилтэн /нэгж/-ийг хяналт шалгалт хийх объектэд саадгүй нэвтрүүлэх;

7. ХАРИУЦЛАГА

- 7.1 Дотоод хяналт, үнэлгээний журмаар тогтоосон хэм хэмжээг зөрчсөн, өгсөн дүгнэлт зөвлөмжийг биелүүлээгүй, хяналт, шалгалтаар илэрсэн зөрчил дутагдыг дахин давтсан ажилтанд “Хөдөлмөрийн дотоод хэм хэмжээ” бусад холбогдох журмын дагуу хариуцлага ногдуулна.
- 7.2 Ажилтан өөрийн буруутай үйлдлээс болж байгууллагад хохирол учруулсан тохиолдолд Монгол улсын хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

8. ХОЛБОГДОХ БАРИМТ БИЧИГ

- 8.1 Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор батлагдсан “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт, шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”
- 8.2 Байгууллагын дотоод хяналт, шалгалтын чиглэлээр баримт бичиг, маягт хөтлөхдөө дараах загваруудыг ашиглана.
 - 8.2.1 Байгууллагын дотоод хяналтын чиглэлээрх хөтөлбөр; *Хавсралт №1, “Дотоод хяналт, шалгалтын ажлын хөтөлбөр”.*
 - 8.2.2 Байгууллагын дотоод хяналтын төлөвлөгөө; *Хавсралт №2, “Дотоод хяналт, шалгалтын төлөвлөгөө”.*
 - 8.2.3 Дотоод хяналт, шалгалт хийх тухай мэдэгдэл; *Хавсралт №3, “Дотоод хяналт шалгалт хийх тухай мэдэгдэл”.*
 - 8.2.4 Дотоод хяналт, шалгалтын тайлан; *Хавсралт №4, “Дотоод хяналт, шалгалтын тайлан”.*
 - 8.2.5 Дотоод хяналт, шалгалтын нэгдсэн бүртгэл; *Хавсралт №5, “Дотоод хяналт, шалгалтын нэгдсэн бүртгэл”.*
 - 8.2.6 Бусад; (дотоод хяналт хийх нэгжийн баримт бичигт хийсэн дүн шинжилгээ гэх мэт)

9. БУСАД

- 9.1 Уг журмын хэрэгжилтэд дотоод хяналтын мэргэжилтэн /нэгж/ хяналт тавина.
- 9.2 Энэхүү журам нь байгууллагын Ерөнхий захирал баталсанаар хүчин төгөлдөр үйлчилнэ.
- 9.3 Энэхүү журмыг холбогдох тушаал шийдвэр, бодлогын бичиг баримт шинэчлэгдэх, өөрчлөгдөх бүрд хянаж, тусгах шаардлагатай өөрчлөлтийг оруулан дахин батална.
- 9.4 Дээр дурдсанаас гадна журамд тухайн цаг үеийн онцлог болон хууль тогтоомжийн өөрчлөлттэй уялдуулан нэмэлт өөрчлөлт оруулж болно.

 УЛСЫН НЭГДҮГЭЭР ҮНДЭСЛЭЛТ	ДОТООД ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫН ЖУРАМ		
	Хүчин төгөлдөр хэрэгжих хугацаа 2023/.... /....	Хувилбар 1	Журмын дугаар УНТЭ –ЗАА -ДХШЖ

Хавсралт №2

БАТЛАВ.

УЛСЫН НЭГДҮГЭЭР ТӨВ ЭМНЭЛГИЙН

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ /

Овог нэр

УНТЭ-ийн оны ДОТООД ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хяналт, шалгалтын зорилт:

.....

.....

Хяналтын шалгуурууд:

.....

.....

.....

Алба хэлтэс /Хамрах хүрээ/:			
Эхлэх Огноо /цаг:		Хариуцсан албан тушаалтны нэр:	
Дуусгах Огноо /цаг:		Тайлан бичих:	
Санал:			
Алба, төв, тасаг, нэгжийн төлөөлөл:			
Огноо	 цаг	Албан тушаалтан:	Хэсэг /үйл явц

Боловсруулсан:

/...../...../...../

Албан тушаал

Гарын үсэг

Овог нэр

Хянасан:

/...../...../...../

Албан тушаал

Гарын үсэг

Овог нэр

 УЛСЫН НЭГДҮГЭЭР УРХИЙН ШАЛГАЛТЫН ХАМРАГДАХ ГАЗАР	ДОТООД ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫН ЖУРАМ		
	Хүчин төгөлдөр хэрэгжих хугацаа 2023/... /...	Хувилбар 1	Журмын дугаар УНТЭ –ЗАА -ДХШЖ

Хавсралт №3

ДОТООД ХЯНАЛТ, ШАЛГАЛТ ХИЙХ ТУХАЙ МЭДЭГДЭЛ

Огноо:/...../.....

Улаанбаатар хот

..... төв, тасаг, алба, нэгжийн танаа
 (дотоод хяналтад хамрагдах газар) (удирдлагын нэр)

Нэг:

.....

..... дотоод хяналт хийх болсоныг мэдэгдэж байна.

Үүнд:

Д/д	Үнэлгээ хийх асуудал	Хугацаа	Дотоод хяналтын мэргэжилтний нэр

Хоёр: Үнэлгээний үр дүнгийн тайланг удирдлагад танилцуулна.

Гурав: Хугацааг хүлээн зөвшөөрсөн эсэхээ эргэж заавал тухайн дотоод хяналт хийх ажлын хэсэгт мэдэгдэнэ.

Холбоо барих утас:

Цахим шуудангийн хаяг:.....

Хүлээлгэн өгсөн ажилтны нэр:

/ он.....сар.....өдөр/

Хүлээн авсан ажилтны гарын үсэг:

/..... он.....сар.....өдөр/

Тэмдэглэл:.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

 УЛСЫН НЭГДҮГЭЭР THE STATE	ДОТООД ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫН ЖУРАМ		
	Хүчин төгөлдөр хэрэгжих хугацаа 2023/... /...	Хувилбар 1	Журмын дугаар УНТЭ –ЗАА -ДХШЖ

Хавсралт №4

ДОТООД ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫН ТАЙЛАН

Огноо:

Тайлангийн дугаар:

Нийт хуудасны тоо:

Эш татсан стандарт /баримт бичиг/:

Үнэлгээ явуулсан огноо:

Үнэлгээний хамрах хүрээ:.....

ТАЙЛАН
1.Дүгнэлт:.....
2. Давуу тал:.....
3.Сул тал:.....
4. Үнэлгээний үед илэрсэн зөрчлүүд:
6.Үнэлгээнд хамрагдсан ажилтнуудын тоо:.....

Үнэлгээ хийсэн: /дотоод хяналт хийсэн нэгж, мэргэжилтэн, ажилтан/

1. /...../...../...../
Албан тушаал Гарын үсэг Овог нэр
2. /...../...../...../
Албан тушаал Гарын үсэг Овог нэр
3. /...../...../...../
Албан тушаал Гарын үсэг Овог нэр

Тайлантай танилцаж, хүлээн зөвшөөрсөн нэгжийн удирдлага:

/...../...../...../
Албан тушаал Гарын үсэг Овог нэр

 УЛСЫН НЭГДҮГЭЭР ТӨГӨЛДӨР ХЭРЭГЖИХ ХУГАЦАА	ДОТООД ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫН ЖУРАМ		
	Хүчин төгөлдөр хэрэгжих хугацаа 2023/... /...	Хувилбар 1	Журмын дугаар УНТЭ –ЗАА -ДХШЖ

Хавсралт №5

ДОТООД ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫН НЭГДСЭН БҮРТГЭЛ

Огноо:

Д/д	Дотоод хяналтын тайлан	Хамрагдсан нэгжийн нэр	Хяналт, шалгалтын шалтгаан	ДХШ-ын бүрэлдэхүүн	Илэрсэн үл тохирол /үүссэн нөхцөл байдал/	Залруулсан байдал /авсан арга хэмжээ/
1						
2						
3						
4						
5						
6						
7						
8						

Бүртгэл хөтөлсөн:

/...../
 /...../
 /...../

Албан тушаал
 Гарын үсэг
 Овог нэр